

БҮХ ХЯТАДЫН АТИХ-ЫН XII ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛИЙН АНХДУГААР ЧУУЛГАН БА БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Н.Төмөр*

Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (БХАТИХ)-ын арванхоёр дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 2013 оны 3 дугаар сард Бээжин хотноо болсон. БНХАУ-ын муж, өөртөө засах орон, хот болон Ардын чөлөөлөх армиас сонгогдсон 2987 төлөөлөгчид их хуралд оролцсоноос 55 үндэстний цөөнхийг төлөөлж 409 (бүх төлөөлөгчдийн 13.7 хувь), эмэгтэйчүүдийг төлөөлж 699 (бүх төлөөлөгчдийн 23.4 хувь), ажилчин тариаланчдыг төлөөлж 401 (бүх төлөөлөгчдийн 13.4 хувь) хүн тус тус оролцлоо. Уг чуулганаар Засгийн газрын ажлын тухай тайлан илтгэлийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жабао тавьж, Улс ардын аж ахуй, нийгмийг хөгжүүлэх 2012 оны төлөвлөгөөний биелэлт, 2013 оны төлөвлөгөөний төслийн тухай, 2012 оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны төсвийн төслийн тухай, БХАТИХ-ын Байнгын хорооны ажлын тухай тайлан, Ардын дээд шүүхийн ажлын тухай тайлан, Ардын дээд прокурорын газрын ажлын тухай тайлан зэрэг тайлан илтгэлийг холбогдох яамны сайд болон дарга нар тавив.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жабао, Засгийн газрын ажлын тухай илтгэлдээ, Хятад улсын нийгэм эдийн засгийн хөгжил болон эдийн засгийн нээлттэй бодлогын асуудлаар голлон яриу. Тэрээр эдийн засагт олсон амжилтын талаар хэлэхдээ, 2012 оны байдлаар Хятад улсын ДНБ 51.9 триллион юань болсноор эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийд хоёрдугаарт орох болов гэжээ¹. БНХАУ-ын ДНБ нь 1978 онд /Хятад улсад эдийн засгийн шинэчлэлт хийж эхэлсэн жил/ 3645.2 сая юань, 1990 онд 18667.8 сая юань, 2000 онд 99244.6 сая юань, 2007 онд 257305.6 сая юань, 2008 онд 300670.0 сая юань², 2009 онд 340902.8 сая юань, 2010 онд 401202.0 сая юань байсан³. Ерөнхий сайд Вэнь Жабао, 2008-2012 онд Хятад улсын эдийн засаг, бүтээн байгуулалтын талаарх ололт амжилтын талаар ярихдаа, өнгөрсөн таван жилийн хугацаанд нийт 31 нисэх онгоцны буудал, 10 мянган тоннын багтаамж бүхий 602 усан боомт, олон тооны гүүр /тэнгисийн арлууд болон гол мөрний эргүүдийг холбосон/ шинээр барьж байгуулан, усны

*МУИС-ийн ОУХС-ийн багш доктор (Ph.D), дэд проф

1. “БНХАУ-ын Засгийн газрын ажлын тухай илтгэл, БХАТИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган, 2013 оны 3-р сарын 5”, Бээжин, 2013, 2 дахь тал
2. “China Statistical Yearbook”, Compiled by National Bureau of Statistics of China, China Statistics Press, Beijing, 2009, pp. 4-5
3. “China Statistical Yearbook”, Compiled by National Bureau of Statistics of China, China Statistics Press, Beijing, 2011, p.5

хэмнэлттэй газар тариалангийн талбайг 77 сая гектараар нэмэгдүүлэн, 19.7 мян. км төмөр зам, үүний дотор 8651 км нь өндөр хурдны төмөр зам, 609 мян. км авто зам, үүнд 42 мян. км нь хурдны авто замыг шинээр байгуулж ашиглалтанд оруулсан бөгөөд эдүгээ нийт 95.6 мян. км хурдны авто замтай болов гэж дурдаад 2012 онд Хятад улсын төсөв санхүүгийн орлогын нийт хэмжээ 11.7 триллион юаньд хүрч, ард түмний амьжиргааны түвшинг дээшлүүлэн хот, хөдөөгийн оршин суугчдын нэг хүний жилийн дундаж орлогын хэмжээг 8.8 хувь, 9.9 хувиар тус тус нэмэгдүүлсэн гэжээ.⁴ БНХАУ-ын Засгийн газар өнгөрсөн таван жилийн хугацаанд байгаль орчныг хамгаалах, хот суурин газрын агаарын бохирдол, тоосжилтын хэмжээг багасгах талаар ихээхэн анхаарал тавьж, 2008-2012 онд нийт 117 сая тн ширэм, 78 сая тн ган болд, 775 сая тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай хоцорогдсон техник технологитой буюу хүлэмжийн хий их хэмжээгээр ялгаруулдаг үйлдвэрүүдийг хааж, үйлдвэрлэлийг зогсоожээ. Мөн цөлжилтийн эсрэг тэмцэх ажлыг эрчимжүүлэн, таван жилийн хугацаанд нийт 11,96 сая гектар талбай бүхий элсэн цөлийг засан боловсруулсан бөгөөд 29.53 сая гектар газрыг ойжуулсан. Таван жилийн хугацаанд Хятад улсын ард иргэдийн амьжиргааны түвшин дээшилж, 2012 оны сүүлийн байдлаар хотын оршин суугчдын нэг хүнд ноогдох орон сууцны талбай дунджаар 32.9 м² байсан бол хөдөө нутгийн нэг хүнд 37.1 м² ноогдох болжээ. Хөдөө тосгоны дэд бүтцийн бүтээн байгуулалт амжилттай явагдаж хөдөө нутгийн нийт 1.46 сая км авто замыг засварлан сайжруулсан буюу шинээр барьж байгуулсан. Хөдөөгийн 300 сая хүний ундны усны аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэн, 4.45 сая хүн амтай хөдөө нутгийг цахилгаанжуулсан гэж БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Засгийн газрын ажлын тухай илтгэлдээ дурджээ.⁵

Вэнь Жабао илтгэлдээ, шинжлэх ухаан, боловсролоор улс орноо хөгжүүлэх бодлогыг амжилттай хэрэгжүүлэн, боловсролын салбарт зориулсан төсвийг жилд дунджаар 21.58 хувиар нэмэгдүүлэн, 2008-2012 онд энэхүү салбарт улсын төсвөөс 7.79 триллион юань зарцуулсан бөгөөд 2012 онд энэхүү зардлын хэмжээ нь ДНБ-ний 4 хувийг эзлэв. Дунд сургуулийн 1-9 дүгээр ангийн 160 сая сурагчдад ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгож, одоогийн байдлаар хот суурин газарт ажил эрхэлж буй хөдөөгийн иргэдийн 12.6 сая хүүхэд хот суурин газрын сургуулиудад суралцаж байна. Шинжлэх ухаан технологийг хөгжүүлэхэд өнгөрсөн таван жилд нийт 827.9 тэрбум юань зарцуулагдаж, энэхүү зардлын хэмжээ 2007 онд ДНБ-ний 1.4 хувийг эзэлж байсан бол 2012 онд 1.97 хувийг эзлэх болов гэжээ.⁶

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Хятад улсын эдийн засгийн

4. “БНХАУ-ын Засгийн газрын ажлын тухай илтгэл, БХАТИХ 12 дугаар их хурлын анхдугаар чуулган, 2013 оны 3-р сарын 5”, Бээжин, 2013, 2-3 дахь тал

5. “БНХАУ-ын Засгийн газрын ажлын тухай илтгэл, БХАТИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган, 2013 оны 3-р сарын 5”, Бээжин, 2013, 6-8 дахь тал

6. “БНХАУ-ын Засгийн газрын ажлын тухай илтгэл, БХАТИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган, 2013 оны 3-р сарын 5”, Бээжин, 2013, 9-10 дахь тал

Бүх Хятадын АТИХ-ын XII дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган ба БНХАУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал

нээлттэй бодлогын талаар ярихдаа, Хятад улсын гадаад худалдааны хэмжээ жилд дунджаар 12.2 хувиар нэмэгдэж, гадаад худалдааны нийт хэмжээгээр дэлхийд хоёрдугаарт, экспортын хэмжээгээр дэлхийн нэгдүгээрт орох болсон. 2008-2012 онд нийт 552.8 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгийг оруулж, гадаадын хөрөнгийн ашиглалтын бүтэц, тогтолцоог сайжруулан чанарыг дээшлүүлэв. Гадаад орнуудад хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ нь 2007 онд 24.8 тэрбум ам.доллар байсан бол 2012 онд 77.2 тэрбум ам.доллар болж, жилд дунджаар 25.5 хувиар өссөн нэмэгдэв гэжээ.⁷ БХАТИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар БНХАУ-ын Даргаар Си Жинпин, дэд даргаар Ли Юаньчао нарыг, БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн даргаар Си Жинпинийг, БХАТИХ-ын Байнгын хорооны даргаар Жан Дэжяныг, Ардын дээд шүүхийн даргаар Жоу Чаныг, Ардын дээд прокурорын газрын ерөнхий прокуроор Цао Жяньминыг тус тус сонгожээ.⁸

БХАТИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы шийдвэрийг үндэслэн БНХАУ-ын Даргын зарлигаар Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдаар Ли Кэчяныг, Ерөнхий сайдын орлогчоор Жан Гаоли, Лю Яньдун, Ван Ян, Ма Кай нарыг, гишүүнээр Ян Жин, Чан Ваньчюань, Ян Цэчи, Го Шэнкунь, Ван Юнвей нарыг, Гадаад явдлын яамны сайдаар Ван И, Батлан хамгаалах яамны сайдаар Чан Ваньчюнь, Улсын хөгжил ба өөрчлөлт шинэчлэлийн хорооны даргаар Сюй Шаоши, Боловсролын яамны сайдаар Юань Гуйрэн, Сангийн яамны сайдаар Лоу Живэй зэрэг 25 яамны сайд, хорооны дарга нарыг томилжээ.⁹

Орчин үеийн Хятадын эдийн засаг, нийгмийн хөгжил нь Хятад оронд өөрчлөлт шинэчлэл явуулах болсон 1978 онд хуралдсан ХКН-ын Төв Хорооны 11 дэх удаагийн сонгуулийн 3-р бүгд хурлын шийдвэрээс эхлэн хэрэгжсэн. БНХАУ нь эдийн засгийн зоримог өөрчлөлт шинэчлэл хийж дотоод зах зээлээ гадаадын хөрөнгө оруулалтад харилцан ашигтай нөхцөлөөр нээж, Хятадын онцлогт тохирсон эдийн засгийн бодлого явуулж байна. 2012 оны 11 дүгээр сард хуралдсан ХКН-ын 18-р хурлын материалаас үзэхэд 2011 онд БНХАУ-ын ДНБ-ний хэмжээ 47.3 триллион юань болж, улсын төсөв санхүүгийн орлогын хэмжээг нэмэгдүүлжээ.¹⁰ Аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэлийн тогтолцооны зохицуулалт амжилттай хийгдэж, дэд бүтцийг бүх талаар хөгжүүлжээ.

Орчин үеийн шинжлэх ухаан, технологиор улс орноо цэцэглэн хөгжүүлэх зорилгоор сансар судлал, тэнгис далай судлал зэрэг салбарт зохих амжилт гарган, хурдны төмөр зам, авто замыг ихээр барьж ашиглалтанд оруулжээ. Хот, хөдөөгийн хөгжлийн уялдаа холбоог сайжруулан, хотжуулалтыг эрчимжүүлж, экологи, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг

7. "БНХАУ-ын Засгийн газрын ажлын тухай илтгэл, БХАТИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган, 2013 оны 3-р сарын 5", Бээжин, 2013, 14 дэх тал

8. "Жэньминь жибао" сонин, 2013.3.15-16

9. "Жэньминь жибао" сонин, 2013.3.16

10. "ХКН-ын 18-р их хурлын бичиг баримтын эмхэтгэл", Бээжин, 2012, 2 дахь тал

арвилан хэмнэх ажлыг бүх талаар өрнүүлж байв.¹¹

Сүүлийн 9 жил дараалан Хятад улс арвин ургац авч 2012 оны байдлаар 589.57 сая тн үр тариа авсан нь 2011 оныхоос 3.2 хувиар, 6.84 сая тн хөвөн авсан нь 2011 оныхоос 3.8 хувь 34.76 сая тн тосны ургамал авсан нь 2011 оныхоос 1.5 хувиар, 134.93 сая тн чихрийн ургамал авсан нь 2011 оныхоос 7.8 хувиар тус тус нэмэгдсэн. 2012 онд үхэр, хонь, гахай, шувууны махны үйлдвэрлэлийн нийт хэмжээ 82.21 сая тн болж, 2011 оныхоос 5.4 хувиар нэмэгдсэн бөгөөд үүнээс 53.35 тн нь гахайн мах байв. 2012 онд 28.61 сая тн өндөг бэлтгэсэн нь 2011 оныхоос 1.8 хувиар, 37.44 сая тн сүү үйлдвэрлэсэн нь 2011 оныхоос 2.3 хувиар тус тус нэмэгдсэн.¹²

2012 онд аж үйлдвэрийн нийт 471 нэр төрлийн бүтээгдэхүүнээс 345 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нь 2011 оныхоос өссөн дүн гарсан. Үүнд: хүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 9.9 хувиар, хөнгөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 10.1 хувиар тус тус өсчээ. Бүс нутгаар нь хувааж үзвэл, зүүн бүс нутагт 8.8 хувиар, төвийн бүс нутагт 11.3 хувиар, баруун бүс нутагт 12.6 хувиар тус тус өссөн. 2012 онд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 4.7 хувиар, боловсруулаагүй гангийн үйлдвэрлэл 3.1 хувиар, боловсруулсан гангийн үйлдвэрлэл 7.7 хувиар, цемент 7.4 хувиар, өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэл 9.3 хувиар, коксжсон нүүрс 5.5 хувиар, хүхрийн хүчил 4.8 хувиар, каустик хужир 3.8 хувиар, химийн аргаар гаргасан мяндас 11.8 хувиар, микро цахим тооцоолон бодох машины тоног төхөөрөмж 11.7 хувиар, авто машины үйлдвэрлэл 3.8 хувиар өссөнөөс суудлын авто машины үйлдвэрлэл 8.3 хувиар тус тус өссөн боловч этилений үйлдвэрлэл 2.5 хувиар, хавтгай шилний үйлдвэрлэл 3.2 хувиар буурчээ.¹³ Харин газрын тосны үйлдвэрлэл 1.9 хувиар өсч, бүтээгдэхүүний олборлолт 207.47 сая тн болов.¹⁴

БНХАУ эдийн засгийн үзүүлэлтээрээ дэлхийд хоёрдугаарт орж байгаа ч хөгжлийн хувьд хөгжингүй орны тоонд ордоггүй хэвээрээ байна. 2011 оны байдлаар тус улсын нэг хүнд ноогдох ДНБ 5471 ам. доллар байсан нь АНУ-аас бараг 9 дахин бага байгаа үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, Хятад улс эдийн засгийн хөгжлөөрөө дэлхийд нэгдүгээрт орж болох ч хөгжингүй орон болохын тулд асар их замыг туулах шаардлагатай. Хятад улс 1.3 тэрбум давсан хүн амынхаа амьжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд их хэмжээний орон сууц, зам, гүүр барьж байна. Энэхүү их бүтээн байгуулалтанд нь шаардлагатай зэс, төмөр, нүүрс, газрын тос, байгалийн хий зэрэг нэн хэрэгцээтэй бүтээгдэхүүнийг гадаад орнуудаас их хэмжээгээр худалдаж авах нь тус улсын хувьд маш чухал болоод байна. Хятад улс нь эрчим хүчний нөөц баялгаар их дутмаг, тухайлбал, дэлхийн байгалийн хийн нөөцийн 7.1 хувь газрын тосны нөөцийн 7.7 хувийг тус тус эзлэх бөгөөд

11. Мөн тэнд

12. <http://www.china.com.cn>, 2013.01.18

13. <http://www.china.com.cn>, 2013.01.18

14. <http://www.cippe.net>, 2013.01.13

Бүх Хятадын АТИХ-ын XII дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган ба БНХАУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал

өнөөгийн олборлолтын хүчин чадлаар тооцоолбол, газрын тосны нөөцийг 15 жил, байгалийн хийн нөөцийг 30 жилийн хугацаанд олборлож дуусах төлөвтэй. Хятад улсад шаардагдах газрын тосны барагцаалбал 50 хувийг гадаад орнуудаас худалдан авдаг.

Дэлхийн томоохон газрын тосны ордуудын газрын тосны нөөц нь жилийн дунджаар 4-6 хувиар багасч байгаа нь газрын тосны хямралыг бий болгох үндсэн шалтгаан болов. 2010-2020 онд Хятад улсад шаардагдах газрын тосны 50-60 хувийг гадаад орнуудаас импортлох шаардлагатай байгаагаас гадна, төмрийн хүдрийн 34-52 хувь зэсийн 72-82 хувь хар тугалгын 45-52 хувь цайрын 53-69 хувь марганецийн 31-38 хувийг мөн импортлох шаардлагатай гэж хятадын эрдэмтэн судлаачид тооцоолжээ.¹⁵ Гиймээс ч тус улс ашиг малтмалын нөөц ихтэй гадаад орнуудыг сонирхон, тэдгээр улс оронтой худалдаа эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд Африкийн орнуудад их хэмжээний хөрөнгө оруулан, гадаад худалдааны хэмжээгээ нэмэгдүүлсэн. 2012 оны эхний 10 сарын байдлаар Хятад улс эдгээр орнуудад нийт 1.5 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалт хийж, 2000 гаруй үйлдвэр, аж ахуйн газрууд үйл ажиллагаагаа явуулж, гадаад худалдааны хэмжээг 163.9 тэрбум ам. долларт хүргэжээ.¹⁶ БНХАУ Африкийн орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаагаа “Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бүс” байгуулах хэлбэрээр хөгжүүлж байна. Тухайлбал, БНХАУ-ын Өнгөт төмөрлөгийн уул уурхайн корпораци 2007 онд байгуулсан “Замби-Хятадын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийг дурдаж болно. 11.58 хавтгай дөрвөлжин км талбайтай энэхүү бүсэд өнгөт төмөрлөгийн чиглэлээр голлон 15 үйлдвэр, аж ахуйн газар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд зэс, кобальт зэрэг өнгөт төмөрлөгийн олборлолт, боловсруулалтаар голлон үйлдвэрлэл явуулдаг.

XXI зуун бол нарийн өндөр технологи, шинжлэх ухаанд тулгуурласан хөгжлийн зуун. Боловсрол мэдлэгт суурилсан эдийн засаг, шинжлэх ухаанд түшиглэсэн хөгжлийн нийгэм рүү орох тусам шинжлэх ухааны үүрэг, түүний ач холбогдол улам бүр өсч, улс орнуудын хөгжилд чухал байр суурь эзлэх болсон өнөө үед БНХАУ-ын хөгжлийг шинжлэх ухаантай уялдуулах, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудал чухал байр суурь эзлэх боллоо. Хятад улс өөрсдөө орчин үеийн нарийн өндөр шинжлэх ухаан, технологийг агуулсан электрон бараа үйлдвэрлэн, брэнд бий болгож эхэлсэн. Жишээ нь дотоодын зах зээлээсээ хальж чадахгүй байсан “Lenovo” компьютер эдүгээ дэлхийд алдартай нэгэн брэнд болжээ. Ийнхүү Хятад улс олон улсын цахилгаан бараа, автомшин, компьютерийн технологийн зах зээлд тун богино хугацаанд хөлөө олоод авлаа. Өнөөдөр Хятад улс шинжлэх ухаан, боловсрол мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих бодлого явуулж, шинжлэх ухаан, боловсролын салбарт зориулсан

15. "Annual Report on China's Energy Development (2008)", Beijing, 2008, p. 316

16. <http://www.specai.caixi>, 2013.04.07.

Бүх Хятадын АТИХ-ын XII дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган ба БНХАУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал

төсвийг жилд дунджаар 21.58 хувиар нэмэгдүүлэн, 2008-2012 онд энэхүү салбарт улсын төсвөөс 7.79 триллион юань зарцуулсан бөгөөд 2012 онд энэхүү зардлын хэмжээ БНХАУ-ын ДНБ-ний 4 хувийг эзэлсэн.¹⁷

Хятад улсын эдийн засгийн энэхүү хурдацтай өсөлт нь олон жил үргэлжилж чадахгүйг тус улсын сүүлийн 6 жилийн ДНБ-ий өсөлт харуулж байна.

БНХАУ-ын ДНБ-ий өсөлтийн байдал 2007-2012 он

он	2007	2008	2009	2010	2011	2012
%	14.2	9.6	9.2	10.4	9.2	7.8

Эх сурвалж: <http://www.news.cn> 2012.02.15

Европын орнуудын санхүүгийн хямрал, эдийн засгийн уналтаас болж, тэдгээр улс оронд хятадын бараа бүтээгдэхүүний хэрэгцээ багассан болон хятадын банкуудын гаргах зээлийн хэмжээ буурч, үйлдвэрлэлийн өсөлт төлөвлөсөн хэмжээнд хүрч чадахгүй, үл хөдлөх хөрөнгийн борлуулалт багассан зэрэг хүчин зүйлээс шалтгаалан БНХАУ-ын 2012 оны ДНБ-ий өсөлт 7.8 хувь хүртэл буурсан нь 2007 оноос хойших хамгийн доод үзүүлэлт боллоо. Дэлхийн хоёр дахь том эдийн засаг ийнхүү суларч эхэлсэн ч 2008 оны санхүү эдийн засгийн хямралыг амжилттай давсан шигээ асар их валютын нөөцөө ашиглан хүнд хэцүү байдлаас гарч чадах байх гэж зарим эрдэмтэн судачид үздэг. 2012 оны байдлаар БНХАУ-ын валютын нөөц нь 3.31 триллион ам. далаарт хүрч, 2011 оныхоос 130 тэрбум ам. доллараар нэмэгдсэн.¹⁸ БНХАУ-ын Засгийн газар санхүү, эдийн засгийн энэхүү хүнд хэцүү байдлаас гарахын тулд зохих арга хэмжээг авсаар байна. 2011 оноос хойш тус улсын Төв банк нь банкуудын байвал зохих бэлэн мөнгөний нөөцийн хэмжээг багасгаснаар зах зээлд илүү их мөнгө нийлүүлэх боломжийг бүрдүүлсэн. Хятад улсын Засгийн газар мөнгөнөөс гадна төсвийн бодлогоороо эдийн засгаа дэмжих бодлого явуулж, хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Жаньси мужийн Шанрао хотын шинэ нисэх онгоцны буудал барьж байгуулах ажилд 666.23 сая юань буюу 105.13 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.¹⁹ Энэхүү нисэх онгоцны буудал Шанрао, Иньтан хоёр хотын 8.5 сая иргэдээс гадна, гадаад дотоодын 30 сая жуулчдад үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөжээ.

БНХАУ-ын төрийн тогтвортой байдал, хямд ажиллах хүч, зах зээлийн багтаамж зэрэг харьцангуй давуу талууд нь гадаад хөрөнгө оруулалтыг татах үндсэн нөхцөл болов. Хятад улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийн хурдац сүүлийн жилүүдэд нэлээд удаашрах хандлагатай болсон ч хөгжлийн дундаж хурдац нь 10.07 хувь байна. БНХАУ дахь гадаад шууд хөрөнгө оруулалт / ГШХО-ын хэмжээ, түүний нийгэм эдийн засгийн үр өгөөж тогтвортой өсөн

17. “БНХАУ-ын Засгийн газрын ажлын тухай илтгэл, БХАТИХ-ын 12дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган, 2013 оны 3-р сарын 5”, Бээжин, 2013, 9 дэх тал

18. <http://www.news.cn>, 2013.01.10

19. <http://www.shihang.org>, 2013.05.13

Бүх Хятадын АГИХ-ын XII дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган ба БНХАУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал

нэмэгдэж байна. АНУ, Япон хоёр улсаас Хятад улсад хамгийн их хөрөнгө оруулалт хийдэг. Үүнд: 2011 оны байдлаар Япон улсаас нийт 46022 нэр төрөл, 79.89 тэрбум ам.доллар, АНУ-аас нийт БНХАУ, ОХУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд өргөжин хөгжиж ирсэн. БНХАУ-ын дарга Си Жиньпин анхны гадаад томилолтоор 2013 оны 3 дугаар сард ОХУ-д төрийн айлчлал хийж, хоёр улсын хооронд газрын тос, байгалийн хий, цахилгаан эрчим хүч, нүүрс зэрэг салбарт хамтран ажиллах тухай 32 бичиг баримтад гарын үсэг зурсан бөгөөд хоёр талын гадаад худалдааны хэмжээг 2015 онд 100.0 тэрбум ам.доллар, 2020 онд 200.0 тэрбум долларт тус тус хүргэхээр тохиролцов.²⁰ 2012 оны сүүлийн байдлаар 61068 нэр төрөл, 67.59 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт тус тус хийжээ.²¹ хоёр улсын харилцан оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 4.0 тэрбум ам.доллар болж, 2004-2012 онд БНХАУ-аас БНХАУ-аас ОХУ-д оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ жилд дунджэр 37.4 хувиар өсч байсан. 2012 онд хоёр улсын хилийн худалдааны хэмжээ 10.37 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны нийт эргэлтийн 11.8 хувийг эзлэв.²²

Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байна. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг 2013 оны 10 дугаар сард БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кечяны урилгаар БНХАУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын хугацаанд “Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр”-т гарын үсэг зурав. Энэхүү хөтөлбөрт, “талууд Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг аль болох эрт шинэчлэн байгуулж, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг чиглүүлэн, цэгцтэй урагшлуулан хөгжүүлнэ” гэж заажээ.²³

БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдааны хамгийн том түнш орон билээ. 2010 онд хоёр орны худалдааны хэмжээ 3.43 тэрбум ам.доллар байсан бол 2011 онд 6.46 тэрбум ам. долларт хүрч 1.8 дахин нэмэгджээ.²⁴ 2013 оны эхний таван сарын байдлаар БНХАУ-аас Монгол Улсад нийт 2.23 тэрбум ам.долларын хөрөнгө оруулжээ.²⁵ Монгол, Хятад хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа цаашид улам өргөжин хөгжих бодит боломж, ирээдүй их байна.

20. "China's Foreign Affairs" (2012), World Affairs Press, Beijing, October 2012, 125, 201 дэх тал

21. <http://www.news.cn>, 2013.04.03

22. Мөн тэнд

23. "Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр", 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, Бээжин хот

24. "Монгол Улсын статистикийн эмхэтгэл", УБ, 2012, 264 дэх тал